



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 7/490

Арвайхээр

**Арвайхээр сумын 14 дүгээр цэцэрлэгийн бүтэц,
орон тооны дээд хязгаар батлах тухай**

Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.8 дахь заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын хамтарсан “Орон тооны жишиг норматив батлах тухай” 2018 оны А/024/11 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 14 дүгээр цэцэрлэгийн бүтэц, орон тооны дээд хязгаарыг 28 байхаар хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан орон тоог мөрдөж, цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлага үүсгэхгүйгээр төсөвтөө багтаан ажиллахыг Арвайхээр сумын 14 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч (Ю.Мандах)-д үүрэг болгосугай.

3. Хавсралтад заасан орон тооны дагуу санхүүжилт олгож, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011101083

Аймгийн Засаг даргын 2020 оны
10.....дугаар сарын ...20...ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт



АРВАЙХЭЭР СУМЫН 14 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
БҮТЭЦ, ОРОН ТОО

№	Албан тушаал	Орон тоо
1	Цэцэрлэгийн эрхлэгч	1
2	Хүмүүжлийн багш	6
3	Дуу хөгжмийн багш	1
4	Арга зүйч	1
5	Туслах багш	6
6	Нягтлан бодогч	1
7	Нярав	1
8	Эмч	1
9	Тогооч	2
10	Угаагч	2
11	Манаач, жижүүр	4
12	Үйлчэгч	2
13	Нийт батлагдсан орон тоо	28

-oOo-